

БАТЛАВ  
‘ДБЭХС’ ТӨХИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР



75-ЫН ЗУУХНЫ ТЭЭРМИЙН ХОЛХИВЧ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БИЧИГ БАРИМТ

/Харьцуулалт/

Гэрээний дугаар: 75-ын тээрмийн холхивч нийлүүлэх: ДБЭХС/202001017

Чойбалсан хот 2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **75-ын зуухны тээрмийн холхивч нийлүүлэх тендер**  
Тендерийн дугаар: **ДБЭХС/202001017**  
Тендер зарласан огноо: **2020.03.10**

**“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **75-ын зуухны тээрмийн холхивч** нийлүүлэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон харьцуулалтын баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000.0 (Тавин мянга) төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Үнийн саналыг **2020** оны **03** дугаар сарын **20** ны өдрийн **14** цаг **00** минутаас өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020** оны **03** дугаар сарын **20** ны өдрийн **14** цаг **15** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг,  
“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн төв байр,  
Утас: 99030576, 88025279  
Факс: 70584545**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <p><b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b></p> <p><b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b></p> <p><b>3. Тендерийн иж бүрдэл</b></p> <p><b>4. Тогтмол үнэ</b></p> <p><b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b></p> <p><b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b></p> <p><b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b></p> <p><b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b></p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) Үнийн санал;</li><li>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</li><li>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</li><li>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</li><li>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</li></ul> <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p> <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |
|---|---|

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>2019 оны санхүүгийн тайлан /аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан байна.)</li> <li>- Татварын албаны тодорхойлолт</li> <li>- Шүүхийн байгууллагын тодорхойлолт</li> <li>- Банк санхүүгийн байгууллагад өрийн үлдэгдэлгүй гэсэн тодорхойлолт</li> </ul>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-aас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Mb-aас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000.0 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn-ээр">www.tender.gov.mn-ээр</a> банкны цахим системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 20 ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 00 минут</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг:<b>Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн төв байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 дугаар давхар, сургалтын өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 20 ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 15минут</b></p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>75-ын зуухны тээрмийн холхивч нийлүүлэх, ДБЭХС/202001017</b>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:





“ДБЭХС” ТӨХК-ИЙН ХУДАЛДАН АВАХ БКЗ-75-39 фб ЗУУХНЫ ТЭЭРМИЙН  
ХОЛХИВЧНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



2019.12.17

Хэрлэн сүм

№	Үзүүлэлтүүд	Тулах холхивч	Өнхөрөх холхивч
1	Марк	NUP 2334 E C4	NUR 2334 E
2	Жин / кг /	85,7	82,6
3	Өргөн / мм /	120	120
4	Гадна диаметр / мм /	400	400
5	Дотор диаметр / мм /	170	170
6	Тосолгооны төрөл	Өтгөн ( смазка, литол 24)	Өтгөн ( смазка, литол 24)
7	Объёмын төрөл	Гадна объём давхар, дотор объём салдаг	Гадна объём давхар, дотор объём салдаг

Тайлбар: Үйлдвэрийн сертификаттай, монгол хэл дээр орчуулсан байх. Тулах холхивч нь тулах дисктэй байна.





ХЯНАСАН:

ТХА-НЫ ДАРГА

ИА-НЫ ДАРГА

ЗТХ-ЫН ИНЖЕНЕР

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

Т.ТӨМӨРБЛАТАР

Б.БЯМБАА

Б.БАТ

С.ГАНБААТАР

2. Баглаа, боодол: *Үйлдвэрийн сав баглаа боодол бүрэн бүтэн хэвийн байх, Үйлдвэрлэсэн улс, холхиевчны эдийн дугаар бичигдсэн байна.*
3. Бараа хүргэх газар: *“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Дорнод аймаг дахь төв агуулах*
4. Бараа нийлүүлэлтийн хуваарь: *Гэрээ байгуулсанаас хойш хуанлийн 30-40 хоногийн дотор*

### **БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
75-ын зуухны тээрмийн холхивч	NUP 2334 EC4 маркын тулах холхивчтой дүйцэхүйц	ш	1	“ДБЭХС” ТӨХК-ийн Дорнод аймаг дахь төв агуулах	Гэрээ байгуулса наас хойш 30 хоногийн дотор	Гэрээ байгуулса наас хойш 40 хоногийн дотор	
	NUR 2334 E маркын өнхрөх холхивчтой дүйцэхүйц	ш	1				

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [төндөрт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [too] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал Үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Төндөрт үнийг тоогоор болон үсгээр							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Төндөрт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>14</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| <p><b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b></p>                             | <p>1.1. Нийлүүлэгдсэн барааг захиалагчийн зүгээс комисс гарч нарийвчилсан үзлэг явуулж, барааны чанарын сертификат, тоо ширхэгийг тулгаж шалгана. Холхивч суулгах, ашиглалтын зааврыг монгол хэл дээр хөрвүүлж бэлтгэсэн байна. Шаардлагатай тохиолдолд лабораторт туршуулна. Нийлүүлэгч тал зардлыг бүрэн хариуцна.</p>  |
| <p><b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b></p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>1) Бараа материалуудыг дагалдаж ирэх үйлдвэрлэгчийн чанарын сертификат (эх хувиар)</li><li>2) Нийлүүлэгдэх барааны нэр, тоо ширхэгийн жагсаалт</li></ul> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <p><b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b></p>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Үйлдвэрлэгчээс 12 сараас багагүй хугацаатай чанарын баталгаа ирүүлсэн байна.</p>  |
| <p><b>4. Төлбөр (ГЕН – 7)</b></p>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>100</b> хувийг барааг хүлээн авсан акт болон компанийн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн төлнө.</p>  |
| <p><b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b></p>                  | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн <b>0.5 хувь</b></p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний нийт үнийн <b>10 хувиас</b> хэтрэхгүй.</p>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусадс хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүний хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]